

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ОРОН
НУТАГТ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХЭД ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 10 дугаар сарын 17

№

Түшиг сум

Энэхүү гэрээг нэг талаас Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Засаг дарга Г. Батболд / цаашид "Засаг дарга" гэх/, нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Техно перспектив ХХК-ний захирал Л.Шинэхүү /цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх/ нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ дараах нөхцлөөр харилцан тохиролцож 2021 оны дугаар сарын-ны өдөр Сэлэнгэ аймгийн Түшиг суманд байгуулав.

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Жаргалмандах 1 дүгээр багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, сум орон нутгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

ХОЁР. Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.


2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах.

2.1.2 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу улирал бүр мэдээлэл өгч, саналыг нь авах, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаанаар үйл ажиллагааны тайлан мэдээллийг хэлэлцүүлэх

2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх.

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулна.

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих.



2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

ГУРАВ. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн
эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэргэжүүлнэ.

3.1.1 Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх.

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах.

3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах.

3.1.4. Туслах ажлын байрны 50 хувиас доошгүй хувийг тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах.

3.1.5. Орон нутгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд 2021 онд /гучин таван сая нэг зуун мянган төгрөгийн нүүрсийг 55 хувийн хөнгөлөлттэй үнээр/ арван ёсөн сая таван зуун мянган төгрөгийн санхүүжилтийг сумаас төлөвлөсөн өвөлжилтийн бэлтгэл ажилд зориулж 520 өрх айл болон сумын халаалтанд 1500тн нүүрсийг төсөл хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлж ажиллана.

3.1.6. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг, сумын иргэдэд тогтмол мэдээлэл өгч байх.

3.1.7. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох.

3.1.8. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөглөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах.

3.1.9. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

69117 + 111

ТЕХНИ
ПЕРСПЕК
ХХТ

УЛААНБААТ

ДӨРӨВ. Хамтын ажиллагааны хороо

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо /цаашид "Хороо" гэх/-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

4.4 Хөнгөлөлтийн хугацаа 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэл байна.

ТАВ. Гэрээний хэрэгжилт

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ЗУРГАА. Гэрээний хариуцлага

6.1. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

ДОЛОО. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.



НАЙМ. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 1 /нэг/ жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг Монгол хэл дээр гурван хувь үйлдэнэ. Зайлшүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТУШИГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА



АШИГТ МАЛТМАЛЫН
БАЙГУУЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:



П. ШИНЭХҮҮ